

“Хавцалын адаг”-ийн дөрвөлжин бичгийн дурсгал

Ё. Жанчив
(МУИС)

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5-р багийн нутаг, Бүрэнцогт тосгоноос зүүн урд орших Бууралхангай уулаас урагш гурав орчим км-т буй “Хавцалын адаг” хэмээх хадан хясаанаа хар бэхээр бичсэн дөрвөлжин бичгийн дурсгалыг МУИС-ийн багш М. Баярсайханы удирдсан тус сургуулийн эх бичиг судлалын III ангийн оюутнууд 2005 оны 6-р сард нээн илрүүлж гэрэл зураг болон хуулбар хийж авсан байна.

Гэвч тэдний авсан гэрэл зураг шаардлага хангахгүй байлаа. Ийм учраас бид (МУИС-ийн багш М. Баярсайхан, Ц. Баттулга, Ё. Жанчив) 2005 оны VIII сарын 3-ы өдөр уул дурсгалыг газар дээр нь очин судалж дижитал аппарат болон видео камераар зургийг нь авсан юм. Бидэнд уг дурсгалыг Баяндэлгэр сумын харьяат малчин 67 настай Сөнид овогт Баатар гуай зааж өгсөн билээ.

Энэхүү бичээс хоёр зүйл бөгөөд том хэмжээтэй нь 4 мөр, бага нь 3 мөр болно. Бичээсийг хавцалын зүүн гар талд орших хадан хясааны өвөр тал буюу наран ургах зүгт сонгодог бичгийн өмнөх үед хамаарах олон хэсэг (10 гаруй бичээс буй) уйгуржин монгол бичээсийн хамт хар бэхээр үйлдсэн байна. Эдгээр бичээсүүд цөм нэг цаг үед бичигдсэн бололтой. Дөрвөлжин үсгийн их бичээс зүүн, бага нь баруун гар талд бичигджээ.

Уул бичээс Монгол улсаас олдсон дөрвөлжин үсгийн 4 дэх дурсгал болж байгаагаараа шинжлэх ухаанд ихээхэн ач холбогдолтой юм. Тухайлбал,

1. Рашаан хадны бичээс¹
2. Хүйтэн голын бичээс²
3. Тайхар чулууны бичээс³
4. Хавцалын адагийн бичээс зэрэг болно.

Эл дурсгал үсгийн тиг хэлбэрийн хувьд нэн тодорхой, жинхэнэ сонгодог хэлбэрээр бичигджээ.

	Их бичээс	Бага бичээс
А. Үсгийн галиг:	1. K'e-lu-re-ne bu-k'un 2. h _o un ta _o y ʒuŋ jij h _u 3. ye ₁ ja _o r-qu-č'in no-ya _o d 4. č'a _o -q'n meor-t'en	1. K'e-lu-ren? ? 2. dij č'eu hu? 3. heu mué ₁ "цен

¹ Эл дурсгалыг хэвлэн нийтэлж судлан шинжилсэн зүйл байхгүй бололтой.

² А. Очир, *Хүйтэн голын монгол ба дөрвөлжин бичгийн дурсгалуудын тухай*, “ОУМЭ-ий VII их хурал, Илтгэлүүдийн товчлол”, УБ., 1997, 117-119; “Mongolica, An International Annual of Mongol Studies”, vol. 11(32), 2001, 93-97; Ё. Жанчив, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал*, УБ., 2002, 111.

³ Ё. Жанчив, Л. Батбилэг, *Тайхар чулууны дөрвөлжин бичиг*, “Түүхийн сэтгүүл, Ephemera Historiae, Academia Doctrinae Mongoli”, t. V, УБ., 2005 (Хэвлэлд).

В. Авианы галиг

1. K'elüren-e бүк'үн
2. fun tay ʒuŋ jɪŋ fu
3. yé jarquǎ' in noyad
4. ǎ' aqān mǎrt' en


1. K'elüren? ?
2. dij ǎ' ū hu?
3. hū mué₁ "цeп

С. Шинэ үсгийн
хөрвүүлэг


1. Хэрлэнээ бүхүн(байх)
2. фунь дай жун жин фу
3. е заргачин ноёд
4. цагаан мөртөн

1. Хэрлэн ?
2. дин чү ху ?
3. хү муй юань

Бид эл дурсгалыг судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах зорилго тавьсан тул элдэв тайлбар сэлт хийсэнгүй.



Их бичээс



Бага бичээс